



**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2017 оны 09 сарын 20 өдөр

Дугаар А/400

Өлгий


Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-гийн "а" заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улаанхус, Цэнгэл, Бугат сумдын захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч	М.Тауке	-Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга
Гишүүдэд:	К.Амалхан	-Нийгмийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн
	Ч.Буян-Өлзий	-Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн мэргэжилтэн
	Р.Авижат	-Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн
	Х.Алдаберген	-Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн
	Б.Досжан	-Архивын тасгийн дарга

2. Хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2017 оны А/369 дүгээр захирамжаар баталсан журмын дагуу хийж, дүнг аймгийн Засаг даргын зөвлөлд танилцуулахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.



ОРЛОГЧ

КАМЕЛИЯТ

00001671

БАТЛАВ
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ  А. КАМЕЛИЯТ

СУМДЫН ЗАСАГ ДАРГА, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ҮЙЛ АЖИЛЛАГАА, АЖЛЫН ҮР ДҮНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ
ХИЙХ, ҮНЭЛГЭЭ ӨГӨХ АЖЛЫН УДИРДАМЖ

2018.09.21

Өлгий

Нэг. Үндэслэл: Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2018 оны жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу.

Хоёр. Зорилго: Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2017 оны А/369 дүгээр захирамжийн хэрэгжилтийг хангах зорилгоор сумдын захиргааны байгууллагуудын бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилт, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын чиг үүргийн хэрэгжилт, санхүү, төсвийн үйл ажиллагаа, орон нутгийн хөгжлийн болон сум хөгжүүлэх сангийн зарцуулалт, бусад нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, үр дүнд хүрсэн бодитой ажлын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ дүгнэлт өгч, ажлын явцыг эрчимжүүлэх, үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн санал, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангахад оршино.

Гурав. Хамрах хүрээ, хугацаа: Тухайн сумын ИТХ-ын ажлын алба, Засаг даргын Тамгын газар, бүх төсөвт байгууллагууд, хоёроос доошгүй багт хүрч 3 хүртэл хоног ажиллана.

Дөрөв. Хяналт-шинжилгээ хийх, үнэлгээ өгөх чиглэлүүд:

4.1. Сумын ИТХ, болон Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын 2017 оны А/369 дүгээр захирамжаар баталсан "Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журмын 11 дүгээр хавсралтад заасан шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээ өгнө.

4.2. Сумын Сум дундын эмнэлэг /ЭМТөв/, сургууль, цэцэрлэг, соёлын төв зэрэг байгууллагуудын үйл ажиллагаанд журмын 13 дугаар хавсралтын шалгуур үзүүлэлтээр тус тус үнэлгээ өгнө.

Тав. Үнэлгээ, дүгнэлт өгөх

5.1. Сумын ИТХ, Засаг даргын Тамгын газар, байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн ажлынхаа дүнгийн талаар сумын удирдлага, түүнд хамрагдсан байгууллагын ажилтнуудад танилцуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх

5.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгийн талаар тодорхой танилцуулга, санал, дүгнэлт бэлтгэж аймгийн Засаг даргын зөвлөлд танилцуулах

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ХЭСЭГ